



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2023 оны 01 дугаар сарын 03

№ 06/01

Улаанбаатар хот

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.10, 18 дугаар зүйлийн 18.1.1, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн \_\_\_\_\_ аймгийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үзүүлж буй үйл ажиллагаа”, “Төрийн байгууллагуудын барилга байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй эсэх”, “Төрийн захиргааны байгууллагуудад Ахмадын сан байгуулсан эсэх”, Булган сумын “Ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль”-ийн дотуур байр, \_\_\_\_\_ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтыг дээрх байгууллагуудын удирдлага, ажлын алба, албан хаагчдын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын талаар амаар болон бичгээр тайлбар авах, дуу, дүрсний болон техникийн хэрэгсэл ашиглан холбогдох баримт бичгийг гаргуулан авч, газар дээр нь танилцах, баримтжуулах, хуулбарлан авч дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

Нэг. Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар:

1. Аймгийн Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гурван зорилтын хүрээнд 10 арга хэмжээг 3,800,000 (гурван сая найман зуун мянга) төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч уг төлөвлөгөөний албажсан эх хувь байхгүй, холбогдох санхүүжилт хийгдээгүй, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс жил бүр 2.0 сая төгрөг төсөвлөдөг гэхээс өөр тайлбар, баримт байхгүй байна.

2. Хорооноос гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байдлыг авч үзвэл 2020 онд 6, 2021 онд 4, 2022 оны эхний 09 дүгээр сарын байдлаар 7 хүүхдэд хүрч үйлчилсэн нь нийт гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн 41.1-57.1 хувьд, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байдлыг авч үзвэл 2020 онд 12, 2021 онд 13, 2022 оны 09 дүгээр сарын байдлаар 17 хүүхэд байгаа нь нийт гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн 51.5-70 хувьд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байдлыг авч үзвэл 2020 онд 11, 2021 онд 6, 2022 оны эхний 09 сарын байдлаар 7 хүүхэд байгаа нь нийт бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн 77-100 хувьд үйлчилгээ үзүүлж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд бүрд аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн

D:\2023 on\A4.month1.docx

150060077



хороо бүрэн дүүрэн хүрч үйлчлэхгүй байгаа нь хүүхдийн халдашгүй, чөлөөтэй байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна гэж дүгнэсэн.

3.Тус хорооноос жилд 4 төрлийн төлөвлөгөө батлан гаргахаас 2022 онд батлагдсан төлөвлөгөө байхгүй, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хангалтгүй, хорооны хуралдааны албан ёсны тэмдэглэл байхгүй, хуралдааны дэгээ батлаагүй, 16 настай хүүхдэд архины хор хөнөөл, Зөрчлийн тухай хууль, стресс, гэр бүлийн хүчирхийлэл, харилцаа хандлагын хичээл орсноос үзэхэд хичээлийн сэдэв, агуулгыг хүүхдийн насны онцлог, сэтгэл зүйтэй уялдуулаагүй, хорооны гишүүдийг идэвхжүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь хорооны гишүүд хууль тогтоомжид заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй, удирдлагын зүгээс зохистой арга хэмжээ аваагүй, аймгийн Засаг даргын орлогчийн манлайлал хангалтгүй байгааг харуулж байна.

4.Бүртгэгдсэн бүх тохиолдолд хувийн хэрэг хангалтгүй хөтөлсөн, үүсгэсэн хувийн хэргүүдэд авагдсан мэдээ, материал ойлгомжгүй, эмх цэгцгүй, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, дүрэм журам, баримт бичгийн стандартыг мөрдөөгүй. Хууль зүйн хороо, ажлын алба үйл ажиллагаагаа явуулахад хорооны гишүүд шаардлагатай судалгаа, мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд хурдан шуурхай гарган өгч, идэвх санаачилгатай ажилладаггүй. Хорооны хуралдаанаар хэлэлцсэн хувь хүн, төрийн болон албаны нууц, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал хангалтгүй байгаа нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчиж болзошгүй эрсдэлийг бүрдүүлсэн байдалтай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-т "...хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах", 5 дугаар зүйлийн 5.2-т "Хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах...эрхтэй", мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй", 12 дугаар зүйлийн 12.1.2-т "хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах", 17 дугаар зүйлийн 17.1.3-д "тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тухайн жилд хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тайлагнаж, олон нийтэд мэдээлэх", Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аймаг, дүүргийн засаг дарга орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо дараах үйл ажиллагааг явуулна" гэж тус тус заасан.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-д хорооны үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтыг тусгасан.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд хийсэн хяналт шалгалтын талаар:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээ, хяналт шалгалтад \_\_\_\_\_ аймгийн Засаг даргын тамгын газар /Нутгийн удирдлагын ордон/, Булган сумын Засаг даргын тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Боловсрол, шинжлэх ухааны газар,



Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, Прокурорын газар, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг 15 байгууллага хамрагдсанаас налуу замыг стандартад нийцүүлсэн 7 байгууллага, стандартын бус налуу замтай 7, налуу зам байхгүй 1 байгууллага, налуу зам нь бариултай 5 байгууллага, бариул байхгүй 9 байгууллага, хүлээлгийн сандалтай 14 байгууллага, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээллийг зайлшгүй хүлээн авах өрөө тасалгаатай 2 байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан таних тэмдэг, тэмдэглэгээтэй 2 байгууллага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөндөө зориулалтын бариултай 2 байгууллага, байгууллагын доторх өрөө тасалгааны хаалга стандартын буюу 85-аас дээш см хаалгатай 3 байгууллага байна. Хаалганы босго 2.5 см-тай 12 байгууллага түүнээс дээш хэмжээтэй 3 байгууллага, байгууллагын гадаа хаалганы өргөн 85-аас дээш см хэмжээтэй 12 байгууллага байгаа нь тус аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлээгүй байна гэж үзсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 9 дүгээр зүйлийн 9.1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх байдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг .....авна” гэж, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Орон сууц, олон нийтийн барилга, байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна”, Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “Барилгын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх зарчмыг баримтална” гэж тус тус заасан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд тэгш хамруулах шаардлагыг MNS 6055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлагыг тооцсон орон зайн, орчин, Үндсэн шаардлага”, MNS 6056:2009 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”, MNS5682:2006 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зам, Техникийн шаардлага”-д тус тус заажээ

Гурав.Ахмадын сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар:

Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс авсан мэдээллээр аймгийн хэмжээд Татварын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг 6-н байгууллага “Ахмадын сан”-ийн данс нээсэн бол Онцгой байдлын газар төвөөсөө нэгдсэн данс үүсгэсэн байна. Удирдамжид заасан Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Соёл, урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжлийн хяналтын газар гэх таван байгууллага “Ахмадын сан” байгуулаагүй байгаа нь ахмад настны хөгжих, хамгаалуулах эрх хангагдаагүй байна гэж үзсэн.



Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3-т “аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах”, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам”-д тус тус заасан.

Дөрөв. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдийн эрхийн талаар:

\_\_\_\_\_ аймгийн \_\_\_\_\_ сумын “Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургууль”-ийн дотуур байрны сурагчдын нөхцөл байдал.

Тус сургууль нь сурагчдын 2 дотуур байртай, 2022-2023 оны хичээлийн жилд нэгдүгээр дотуур байранд 98 сурагч, хоёрдугаар дотуур байранд 66 сурагч тус тус амьдарч байна. Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн нэгдүгээр дотуур байрны өрөө, хүүхэд хөгжлийн өрөө, ариун цэврийн өрөөний хана, таазны зарим хэсгийн шавардлагаа хагарч, хуурсан, цонхнууд цуурч цацраг үүссэн, цонхны хажуу талын хана мөөгөнцөртсөн, зарим өрөөний гэрэл асдаггүй, өрөөнүүдийн тохижилт муу, угаалтуур хүйтэн устай, дулаан хангалтгүй, гал зуух зориулалтын бус газарт байрласан;

Хоёрдугаар дотуур байрны хүүхдийн өрөөний хананы шавар, шохой хуурч унасан, зарим цонх цуурсан, дотор орчны гэрэлтүүлэг муу, байрны 00-ын өрөөнд бие засах боломжгүй учир гаднах модон жорлонд сурагчид бие засдаг, угаалтуур хүйтэн устай, дотуур байранд ариутгал халдваргүйжүүлэлт хийгдээгүй, бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан угаалтуур, шүршүүр байхгүй, алжаал тайлах өрөө тасалгаагүй, сурагчдын өрөөний таазаар дулааны шугам, сүлжээг ил байрлуулсан, өрөө тасалгаа хүйтэн зэрэг нь сурагчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөн гэж үзэхээр байна.

\_\_\_\_\_ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн дотуур байрны суралцагчдын нөхцөл байдал.

\_\_\_\_\_ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын дотуур байранд 2022-2023 оны хичээлийн жилд 40 суралцагч байрлаж байна. Тус төвийн дотуур байрны нөхцөл байдалтай танилцахад байрны дотор талын зарим хэсгийн хананы элс шавар хуурч, будаг замаск холцорч унасан, өрөөнүүдийн гэрэлтүүлэг муу, шал зарим хэсгээрээ цөмөрсөн, хаалганууд хагарч, зай гарсан, өрөөнүүдэд хичээлийн ширээ, хувцасны шүүгээ байхгүй, байрлаж суралцахад таатай орчин бүрдээгүй байна. Энэ талаар \_\_\_\_\_ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал \_\_\_\_\_ “...манай оюутны дотуур байрыг ковидын нөхцөл байдлын үед тусгаарлах байрны зориулалтаар ашигласан. Энэ үеэр дотуур байрны өрөөнүүдийн хаалга эвдэрсэн, шал нь нэмж цөмөрсөн цаашид яаралтай их засвар оруулах шаардлагатай байгааг аймаг, орон нутгийн удирдлагад удаа дараа уламжилсан” гэх тайлбар өгсөн бөгөөд энэ байдлыг Комисс дотуур байрны суралцагчид, стандартын шаардлагад нийцсэн орчин нөхцөлөөр хангагдаагүй байна гэж үзсэн.

Шалгалтын явцад дээр дурдсан 2 сургуулийн дотуур байрны үйл ажиллагаатай холбоотой дотоод журам, хяналтын камер ажиллуулах журам, суралцагчидтай хийсэн гэрээ зэрэг баримт бичигтэй танилцаж дүн шинжилгээ хийхэд утга агуулгын хувьд



алдаатай, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гараагүй, холбогдох дүрэм журмыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулаагүй, дотуур байранд хяналтын камер байршуулсан боловч, түүнд агуулагдаж байгаа бичлэг, мэдээллийг хэрхэн ашиглах, хувь хүний нууцыг хамгаалахад чиглэгдсэн дүрэм журам батлаагүй, дотуур байрны багш ажилчдын нийгмийн баталгааг хуульд тогтоомжид заасны дагуу бүрдүүлээгүй, илүү цаг, үр дүнгийн урамшууллыг тогтмол олгодоггүй, байрны засвар үйлчилгээг дотоод нөөц бололцоо хэлбэрээр шийдвэрлэж байгаа, дотуур байрны хоолны хүрэлцээ муу зэрэг нийтлэг зөрчил илэрсэн нь хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, хүний халдашгүй чөлөөтэй байх, сурч боловсрох эрхийг зөрчсөн байна.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцын 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн b "...дунд боловсролын олон хэлбэр, түүний дотор ерөнхий болон мэргэжлийн боловсролыг хүүхэд бүрд хүртээмжтэй болгох, хөгжүүлэх, шаардлагатай тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх буюу үнэ төлбөргүй боловсрол олгох", мөн зүйлийн 2 дах хэсэгт "Оролцогч улсууд сургуулийн дэг журмыг дэмжих үүднээс хүүхдийн нэр төрд хүндэтгэлтэйгээр хандуулах бүхий л арга хэмжээг энэхүү Конвенцид нийцүүлэн авна", Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11-т "... хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах" гэж тус тус заасан.

Мөн сурагчдын дотуур байрны үйл ажиллагаа, орчин нөхцөл, хоолны илчлэг, амьдрах болон ариун цэврийн өрөө, ариутгал, цэвэрлэгээ, галын аюулгүй байдал, соёл хүмүүжлийн арга хэмжээнд баримтлах шаардлагыг Монгол Улсын стандарт MNS 6781:2019 "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ, Ерөнхий шаардлага" стандарт, MNS 6782:2019 "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандарт, MNS 6890:2020 "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага"-д тус тус заажээ.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дугаар зүйлийн 7-д "Монгол Улсын Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах...", "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1-д "Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцна" гэж заасныг тус тус удирдлага болгон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу дараах Шаардлагыг хүргүүлж байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиглэлээр

1. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу явуулж хэвших, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжилтийг тогтмол хугацаанд үнэлж байх;
2. Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;



3. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон хүүхдийн шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх (хууль зөрчсөн хүүхдэд зөв хүмүүжил олгох, хорт зуршлаас ангижруулах, мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаан, эрх зүйн анхан шатны сургалт) чиглэлээр байгууллагуудын хамтын ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
4. Хууль зүйн хорооны гишүүд болон хамтран ажилладаг байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах давтан сургалтын хөтөлбөр боловсруулж батлах, эхний улирлын сургалтыг зохион байгуулах;
5. Хорооны хуралдааны дэгийг батлах, хорооноос гаргах зөвлөмж, тэмдэглэл, албан тоотыг Хорооны ажлын алба буюу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хэрэг хөтлөлтөөс тусад нь бүртгэл хөтлөх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталж, хадгаламжийн нэгжийг архив, албан хэрэг хөтлөлтийн дагуу бүрдүүлэх, хорооны гишүүн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох горимыг тогтоож хэрэгжүүлэх;
6. Ажлын алба нь хууль зөрчсөн хүүхдийн эрүү, зөрчлийн хэрэг, хувийн мэдээлэл, Хууль зүйн хорооноос үзүүлсэн үйлчилгээг агуулсан хувийн хэргийг хүүхэд бүрд нээж ажиллах, үйлчилгээ үзүүлж дууссаны дараа хорооны бүртгэл мэдээллийн санд шаардлагатай мэдээллийг оруулах, хувийн хэргээс төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцад хамаарахгүй баримт мэдээллийг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчид хүлээлгэн өгөх горимыг тогтоох;
7. Гэр бүл, ахуйн орчинд хүүхдийн дэргэд согтууруулах ундааны зүйл хэрэглэх зөрчлийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллийн болон бусад дуудлага мэдээллээр очихдоо тухайн объект дотор хүүхэд байгаа эсэхийг тодруулж, хамтарсан багтай уялдаа холбоотой ажиллах.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр

1. Аймгийн хэмжээнд нийтийн тээвэр, албан газар, олон нийтийн үйлчилгээний газар, орон сууц, гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон нийтийн газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандарт мөрдөгдөж байгаа эсэхэд үзлэг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах, хүрэлцээтэй байх орчин нөхцөл бүрдүүлээгүй аж ахуй нэгж байгууллагын барилга байгууламжийг холбогдох стандартад нийцүүлэх, цаашид стандартад нийцээгүй барилга байгууламж, зам талбайг хүлээн авч, ашиглалтад оруулахгүй байх шийдвэрийг гаргаж холбогдох албан тушаалтан, аж ахуй нэгж, олон нийтэд танилцуулах;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах.

Ахмад настны эрхийн чиглэлээр

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам"-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагуудад ахмадын сан байгуулах арга хэмжээ авч, зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдийн эрхийг хангах чиглэлээр

1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нөхцөл байдалтай биечлэн танилцаж, багш ажилчдын санал хүсэлтийг сонсох ажил зохион байгуулах;



2. Дотуур байранд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрах, сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, гадна, дотно орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, хүүхэд хөгжлийн болон хичээл давтах өрөө, номын санд засвар үйлчилгээг хийх, шаардлагатай бол шинээр ашиглалтад оруулах, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэхэд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;
3. Дотуур байрны ариун цэврийн болон усанд орох өрөөний тохижилт, орчин нөхцөл, сан техникийн угсралт, ил задгай байрлуулсан цахилгааны монтаж болон дулааны шугам сүлжээг стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах;
4. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутны дотуур байрыг их засвар болон Нэгдүгээр сургуулийн дотуур байрны дулааныг хэвийн байдалд оруулахад дэмжлэг үзүүлэх, засварын ажлын явц байдалд хяналт тавих ажлын хэсгийг байгуулан ажиллуулах;
5. Дотуур байранд амьдрах оюутны хоногийн хоолны зардлыг нэмэгдүүлэх талаар Засгийн газраас гаргасан шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах;
6. Дотуур байранд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг нь хангуулах;
7. Дотуур байрны багш ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгох талаар холбогдох албан тушаалтанд чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд Шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн талаар нотлох баримтын хамт мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 40 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Б.ЭНХБОЛД